

Мэдээний эх сурвалж: www.oie.int

Х.П.Шнайдер, AGRIVET International Consultants, Намиб Улс

ДАЭМБ-аас "Мал эмнэлгийн боловсрол, Мал эмнэлгийн мэргэжлийн зовлолийн үүрэг" сэдвээр зохион байгуулсан Дэлхийн мал эмнэлгийн боловсролын 3 дугаар зовлогоонд тавьсан илтгэл, 2013.12.05

Орчуулагчаас огч буй товч тайлбар:

Мал эмнэлгийн мэргэжлийн зовлол (МЭМЗ) нь Монгол Улсын Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн тосолд 'Малын эмч нарын танхим' гэдэг нэршлээр орсон.

Хураангуй

Улсын Мал эмнэлгийн алба (МЭА) нь амьтны эрүүл мэндийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй торийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас тогтоно. Малын эмч нь мал амьтан, үйлчлүүлэгчийн омно хүлээх хариуцлагаар хязгаарлагдахгүйгээр амьтантай зүй зохистой харьцах, хүнсний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны эрүүл мэнд, нийтийн эрүүл мэнд, био-хамгаалал зэрэг нийтийн сайн сайхны толоо нийгмийн хүлээлтэд нийцэх үүрэгтэй. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага (ДАЭМБ)-аас МЭА-ны чанарын талаар олон улсын стандарт болгон баталсан Хуурай газрын амьтны эрүүл мэндийн код (Terrestrial Animal Health Code)-ын Бүлэг 3.1 ба 3.2-ыг мордож, мал эмнэлгийн сайн засаглалыг тохинуулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тулгуур багана бол Мал эмнэлгийн мэргэжлийн зовлол (МЭМЗ/Veterinary Statutory Body) юм.

Мал эмнэлгийн сайн засаглалыг томъёологч гол элементэд мал эмнэлгийн чанартай боловсрол болон мал эмнэлгийн мэргэжлийг үр дүнтэй зохицуулах тогтолцоо багтана. Үүнээс 'мэргэжил' гэдэг үгийг цохон тэмдэглэе.

Малын эмч, мал эмнэлгийн мэргэжлийн туслах ажилтан (МЭМТА)-уудыг итгэмжлэх/бүртгэх ажлыг зохицуулах, мал эмнэлгийн үндсэн (initial) болон үргэлжилсэн боловсролын минимум стандартыг тодорхойлох, мэргэжлийн дүрэм, ёс зүйн стандарт тогтоох, мөрдүүлэх замаар мал эмнэлгийн мэргэжлийн ондор чанар, ёс зүйг хангах зорилго бүхий МЭМЗ-ийн үндсэн үүрэг, хариуцлагыг энэхүү бүтээлд танилцуулав.

МЭМЗ-ийн эрх мэдэл, чадавхад хууль эрх зүйн зохистой орчин, улс төрийн хэт нолооноос ангид байх, ил тод зарчмаар үүргээ гүйцэтгэх боломж олгохуйц захиргааны болон санхүүгийн дэмжлэг чухал гэдгийг онцлон хэлье. Энэ нь Мал эмнэлгийн сайн дадлын код (Code of Good Veterinary Practice)-д үндэслэн чанарын менежментийн тогтолцооны протокол, зааварчилгаа болон мал эмнэлгийн үйл ажиллагааны бүхий л чиглэлээр мэргэжлийн твшинд ажиллах дүрэм боловсруулна гэсэн үг юм.

Эцэст нь дүгнэхэд, ДАЭМБ-аас баталсан Мал эмнэлгийн сайн засаглал, мал эмнэлгийн чанартай үйлчилгээний олон улсын стандартыг МЭА хэрэгжүүлэхэд үр дүн, зохистой нооц бүхий МЭМЗ гол үүрэг гүйцэтгэнэ.

Үргэлжлэлийг [энд](#) дарж үзнэ үү